

ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН
ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 ОН

МОДОТ

ЗОРИЛГО : ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЖ БОДИТ
ҮР ДҮНД ХҮРЭХ

УРИА : ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ

ЗОРИЛТ-1 : ХУВЬ ХҮНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ

**НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ /Боловсрол, Эрүүл мэндийн үйлчилгээ,
Өрх гэр бүл ,хүүхэд,Нийгмийн хамгаалал, Аялал жуулчлал, спорт урлаг
ХӨГЖЛИЙГ ХҮРТЭХ ХЭНТИЙЧҮҮД / ХӨГЖЛИЙГ ХҮН БҮРТ**

- 1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, нутаг орныхоо байгаль, түүх, соёл, уламжлалаараа бахархдаг "Зөв Монгол хүүхэд" аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2 Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтаныг томилох, чөлөөлөхөд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Боловсролын зөвлөл-ийн саналыг харгалзана.
- 1.3 Орон нутгийн бодлогоор хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн , боловсон хүчнийг аймгийн МСҮТ-д бэлтгэнэ.
- 1.4 СӨБ-н хамран сургалтыг нэмэгдүүлж нормативт тоонд хүргэнэ.
- 1.5 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах "Зөв дархлаа" хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 1.6 ЭМТ-н боловсон хүчнийг мэргэшүүлэх, боловсролын түвшинг ахиулах зорилт тавин хэрэгжүүлнэ.
- 1.7 Эрүүл мэндийн салбарын эм хангамж, хүний нөөц, удирдлага менежментийг боловсронгуй болгох бодлого хэрэгжүүлнэ.
- 1.8 Дуудлага, түргэн тусламжийн үйлчилгээ , зохион байгуулалтыг сайжруулж , чанар хүртээмж шуурхай байдлыг эрс сайжруулна.
- 1.9 Амны хөндийн эрүүл мэнд " хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.10 Архигүй Хэнтийчүүд-2 хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 1.11 Орон сууцны нөхцөлөө сайжруулах чиглэлээр орон сууц барих өрхөд барилгын модон материал нийлүүлэх менежментийг боловсруулж холбон зуучилж дэмжинэ.
- 1.12 Хар зүрхний Хөх нуурыг " Алтан цагираг " аялал жуулчлалын бүсэд хамруулж хөгжүүлнэ.
- 1.13 Хар зүрхний Хөх нуурын алтан ургийн хаадын хөшөөг сэргээн засварлах
- 1.14 Сумаас төрөн гарсан алдартнуудыг алдаршуулах , амжилт гаргасан шинэ залуу алдартнуудыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 1.15 Соёлын төвийн албан хаагчдийг давтан сургалтанд хамруулах , тоног төхөөрөмжийг шинэчлэх
- 1.16 Сумын төвийн соёлын төвийн барилга барьж зориулалтын бус орчинг өөрчлөх

**ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ / Жижиг дунд бизнес, Хөдөлмөрийн зах зээл,
Аж үйлдвэрлэлийн салбар, Дэд бүтэц, Эрчим хүч, Барилгын салбар, Шинжлэх ухаан
технологи, Аялал жуулчлал/**

- 2.1 "Ажлын байр-Аймгийн хөгжил" хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.

Хүснэгт



- 2.2 Суманд НААҮ-г нэг цэгт төвлөрүүлж ЖДҮ-г дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.3 Түншийн харилцааг дахин сэргээж , гадаад харилцааг хөгжүүлж , төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажлын байр нэмэгдүүлнэ.
- 2.4 Авлига , ашиг сонирхолын зөрчлийг судлан ах дүүс , төрөл садны төрийн албаны бүтцийг таслана.
- 2.5 Цэвэр бохир усны сүлжээг өрх, орон сууцанд оруулах, удирдлага зохион байгуулалт хийнэ.
- 2.6 Бирж , нядалгааны цэгийн эхлүүлсэн ажлыг дуусгана.
- 2.7 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд, төмс хүнсний ногоо, жимсний үйлдвэрлэлийг дэмжиж, аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.8 Цэвэр усны хүртээмжийг сайжруулж, халуун усны үйлчилгээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах бодлого , зорилтыг тусгаж төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 2.9 Хог хаягдалын менежментийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.10 Уул уурхайн нөхөн сэргээлт үйл ажиллагаанд төрийн, мэргэжлийн, иргэний хяналтыг сайжруулж бүрэн хийдэг тогтолцоог бий болгоно.
- 2.11 Олон жил ажиллаагүй , 2000 оноос ашиглаагүй хайгуулын лицензүүдийн асуудлыг судлан шийдвэрлүүлж, цуцлуулж бэлчээр чөлөөлүүлнэ.
- 2.12 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж үйл ажиллагаа нь жигдэрч буй ЖДҮ-г дэмжих бодлого барьж зохион байгуулалт хийнэ.
- 2.13 ЦДАШ-н шинэчлэл хийгээгүй үлдсэн 3 эгнээг хамруулж шинэ суурьшлын бүсийн ЦДАШ-н асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.14 Орон нутгийн чанартай зам гүүрийг засварлах, шинээр барьж байгуулах ажлыг төр хувийн хэвшлийн боломжит бусад эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.
- 2.15 Сумын тохижилт үйлчилгээний гэрээт нэгжийг төрийн машин механизм, тоног төхөөрөмжийг түшиглэн ажиллуулна.
- 2.16 Банкны үйлчилгээг нэмэгдүүлж үйлчилгээний цэгийн төвлөрөлийг түшиглэж АТМ байрлуулах ажлыг судлан шийдвэрлэнэ.
- 2.17 Шуудангийн тогтолцоог сайжруулж хэвлэл түгээлтийн системийг сайжруулна.

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ / Орон нутгийн хөгжил, Шинэ сум, хөдөө аж ахуй, Бэлчээр, Газар тариалан, НУТАГТАА ЭЗЭН ХЭНТИЙЧҮҮД

- 3.1 Сумын төвийн дахин төлөвлөлттэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлан мөрдүүлнэ.
- 3.2 ОНХС-г сумын хэтийн төлөвлөлт, мөрийн хөтөлбөртэй уялдуулан хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж иргэдийн хяналтыг бий болгоно. /аймгаас хувиарласан төсвөөр/
- 3.3 "Хашаандаа сайхан амьдаръя" бие засах газраа өөрчилж зэрэг ахуйн төслүүдийг суманд хэрэгжүүлнэ.
- 3.4 Байгальд ээлтэй малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.5 " Чинээлэг малчин" хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 3.6 Шинээр ногоо тарих иргэнийг дэмжих "сургалтын талбай" г өргөжүүлэн 10 га-д хүргэнэ.
- 3.7 Дарш , тэжээлийн ургамал тариалалтыг дэмжин , газрыг төсөл сонгон шалгаруулалтаар дотооддоо олгох зохион байгуулалт хийнэ.
- 3.8 Согоот багийн Царгасын туршилтын талбайг сэргээн зохион байгуулна.
- 3.9 Агро паркийн хөрөнгө оруулалтыг хянаж олгогдсон 20 га газрын ашиглалтыг сайжруулна.
- 3.10 Согоот багийн хүнсний ногооны хуучин талбайг усжуулах ажлыг зохион байгуулна.
- 3.11 Багийн төвүүдэд халуун хүйтэн зоорь барих ажлыг хийж, ажлын байрыг нэмэгдүүлж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.12 Байгаль хамгаалах нөхөрлөл, идэвхитэн байгаль хамгаалагч томилох зэргээр удирдлага зохион байгуулалт хийж байгаль хамгаалах тогтолцоог сайжруулна.
- 3.13 Сумын нутаг дэвсгэрт байгаа байгалийн дагалт баялгыг гэрээгээр эзэнжүүлж хяналтыг чангатгана.
- 3.14 Орон нутгийн өмчийн эзэнгүйдэл, шамшигдуулалт , үнэгүйдлийг арилгаж нийтийн эрх ашигт нийцүүлэн ашиглана.

Handwritten signature



3.15 Хуучин гудамжны гэрэлтүүлгийн урсгал засварыг хийнэ.

3.16 Бэлчээр усжуулалтыг хийж, цөлжилтийг бууруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ/ Иргэнээ хамгаалдаг хууль, хуулийг дээдлэгч ХЭНТИЙЧҮҮД

- 4.1 Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж ИТХ-ын хуралдааныг иргэдэд нээлттэй болгоно.
- 4.2 ГХУС-х ажлыг эрчимжүүлж, үүнд : нөхөрлөл, хөршийн холбоо, 10- тын зохион байгуулалт зэргийн үйл ажиллагааг хамруулна.
- 4.3 Хуулийн цоорхой, гажуудал, давхардал , хуулиас дээгүүр дүрэм журмын хүрээнд иргэд хохирдог явдалд судалгаа шинжилгээ хийж УИХ-ын гишүүнд уламжилна.
- 4.4 ЗДТГ, төрийн үйлчилгээний бүх байгууллагуудад "Тосч үйлчлэх" үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 4.5 Иргэдэд хуулийн анхан шатны зөвлөгөө, тусламж үзүүлдэг "Иргэний танхим"-ыг сэргээн ажиллуулна.
- 4.6 Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж , нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, шударга, хүртээмжтэй болгох удирдлага зохион байгуулалт хийнэ.
- 4.7 Гэр бүлийн хүчирхийлэл ,нийтийн амгалан тайван байдлыг хангах тусгай цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 4.8 Архидан согтуурах зэрэг нийгмийн буруу зуршлын хор хөнөөлийг сурталчилан эрсдэлийг бууруулах зохион байгуулалт хийж ажиллана.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ / Байгаль орчин, ногоон хөгжил /

- 5.1 Зөвхөн мод, бут сөөг тарих бус арчлах ургуулах ажлыг зохион байгуулж ногоон орчинг нэмэгдүүлнэ.
- 5.2 ТГ-ын ногоон төгөл, залуучуудын ногоон бүс , нутгийн бахархалт цэцэрлэгт хүрээлэн зэргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 5.3 Өмнө нь баригдсан ахмадын танхим, ёслол хүндэтгэлийн өргөө зэргийг иргэдийн чөлөөт цагийг амгалан тайван өнгөрөөх орчин болгон ажиллуулна.
- 5.4 Цөлжилтийг бууруулах хүчин зүйлүүдийг судлан эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулна.
- 5.5 Ойн ангийн ажлыг сэргээж , мэргэжлийн боловсон хүчнээр ханган ойжуулалт, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх ажлыг технологийн дагуу хийнэ.
- 5.6 Ойн ангийн мод үржүүлгийн газрыг сэргээж бодлогоор дэмжинэ.
- 5.7 Байгаль хамгаалах ажилд идэвхи санаачилга гаргасан , байгальд ээлтэй орчин бүрдүүлсэн иргэн, нөхөрлөл , ААНБ-г урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
- 5.8 Булаг , шандны эхийг хамгаалах ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хийнэ.
- 5.9 Түүхийн болон байгалын хосгүй дурсгалт газарт Хар зүрхний Хөх нуурын хамгаалалтын дэглэмийг сайжруулна.
- 5.10 Сумын төв, нийтийн үйлчилгээний цэгийн ундны усны аюулгүй байдлыг хангана.

Мөрийн хөтөлбөрийг тусгай төлөвлөгөө гарган аймаг , сумын нийгэм , эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан хэрэгжүүлнэ.



МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ НЭГТГЭСЭН :
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ДЭД ДАРГА *[Signature]* /Н.МӨНХТУЯА /

2020.06.15